

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2018 ОНЫ
01 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2018.01.30

Нэг. Зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын бүтцийн нэгжүүдийн 2018 оны 01 дүгээр сарын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаарх санал, зөвлөмжийг удирдлагад танилцуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хоёр. Үндэслэл

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв.

Гурав. Төлөвлөгөөний хэрэгжилт

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс 11, Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэс 19, Захиргаа, санхүүгийн хэлтэс 28, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нийт 58 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 43, хэрэгжих шатанд 8, хэрэгжилт хангалтгүй 3, хэрэгжээгүй 2 арга хэмжээтэй, биелэлт **84,0** хувьтай байна.

№	Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажлын тоо	Хэрэгжилтийн байдал /хувиар/					Нэгжийн дүн
			Бүрэн хэрэгжсэн 100 хувь (90-100 хүртэл хувь)	Хэрэгжих шатанд 70 хувь (50-89 хүртэл хувь)	Хэрэгжилт хангалтгүй 30 хувь (10-49 хүртэл хувь)	Хэрэгжээгүй 0 хувь (0-9 хүртэл хувь)	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй	
1	ХЗХБХ	11	8	1	1	1	-	81,81
2	ТМССХ	19	13	3	2	1	-	80,00
3	ЗСХ	28	22	4	-	-	-	87,53
	Дүн	58	43	8	3	2	-	83,98

Дөрөв. Санал зөвлөмж:

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэст

1. “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлэх” арга хэмжээ нь төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгагдсан арга хэмжээ учир төвийн захирлын 2017 оны А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг ажил, үүргийн хуваарилалт хийж ажлаа эрчимжүүлэх шаардлагатай;

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ЗТХ-ийн сайдын 2017 оны 115 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ХЗХБХ-ийн дарга М.Батмягмар, ахлах мэргэжилтэн Б.Батнасан, ХШУДАХА Э.Осоржамаа нар, төвийн захирлын 2017 оны А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийг М.Батмягмар дарга ахалж, гишүүдэд Б.Батнасан, Ц.Оюунбат, О.Эрдэнэтулга, Э.Осоржамаа, О.Анужин, Б.Оюунчимэг нар багтсан.

Иймээс ажлын хэсэгт нэр нь ороогүй ажилтанд санал боловсруулах ажил хариуцуулахгүйгээр нэр нь орсон мэргэжилтнүүдийг татан оролцуулах, жирэмсэний болон амаржсаны амралт авсан

Б.Оюунчимэгийн оронд ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргилыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулах, ингэхдээ захирлын тушаалаар нэмэлт оруулж шийдвэрлүүлэх;

2. ЗТХЯ-ны улсын байцаагчийн 38-07-070/14 дугаарын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан мэдээллийг 02 дугаар сарын 12-ны дотор ирүүлэх;

3. Хэлтсийн 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө батлагдахгүй байгаа шалтгааныг захирлаас лавлаж, нөхөн батлуулах арга хэмжээ авах;

Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэст

4. “Хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаа, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж. Аюулгүй ажиллагааны шаардлага ба хяналтын арга” стандарт, “Дэд бүтцийн харилцаа холбооны мэдээлэл болон аюулгүй байдлын нэгдсэн мэдээллийн сан” санамжийн орчуулгад хяналт тавьж ажиллах, нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар нэр томьёо, мэргэжлийн хэллэгт оруулах ажилд ХЗХБХ-ийн холбогдох ажилтнаас санал авах, хянуулах, хамтран ажиллах;

5. Салбарын хууль тогтоомж, дүрэм, журмын эмхтгэл, програм хангамж, компьютер, техник хэрэгсэлтэй холбоотой үнийн санал, зардлын тооцоо зэрэг судалгааны 4 ажлыг тайланд сард төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлжээ.

Эдгээр ажлын биелэлтийг харахад зарим нь дөнгөж нэг хуудас бүхий үнийн санал байгаа бөгөөд “судалгаа хийх” /аливаа юмны зүй тогтлын учрыг олох, судлах үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажил/ гэсэн томъёололтой нийцээгүй бөгөөд цаашдаа ийм ажил төлөвлөж хэрэгжүүлэхдээ нэгтгэх буюу оновчтой томъёолж тусгах шаардлагатай;

6. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг орхигдуулалгүй бүрэн гүйцэд тайлагнах;

Захиргаа, санхүүгийн хэлтэст

7. Төлөвлөсөн арга хэмжээтэй хамааралгүй ажлыг төлөвлөгөөний биелэлт хэсэгт бичихгүй байх, тайлан мэдээг үнэн зөв гаргах;

8. “Ажилтны ажлын үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохион байгуулалтаар хангаж ажиллах” арга хэмжээг тайлант сарын дараагийн сарын 5-ны дотор хэрэгжүүлэхээр тусгаж байх, харин улирал, хагас жилийн ажлын үр дүнг үнэлж дүгнэх ажлыг улирал, хагас жилийн сүүлийн сард төлөвлөж хэрэгжүүлэх;

9. Бусад хэлтэстэй харьцуулахад төлөвлөж хэрэгжүүлж буй ажлын тоо олон байна. Хэлтсийн хэмжээнд чанартай, үр дүнтэй цөөн тооны ажил төлөвлөж хэрэгжүүлэх.

ХЯНАСАН:

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:

ХЗХБХ-ИЙН ДАРГА

М.БАТМЯГМАР

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

ЗСХ-ИЙН ДАРГА

Н.ШИНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА

